

“БОЛОВСРОЛ СУДЛАЛ” СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АГУУЛГА, АРГА ЗҮЙН СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮН

Л.Жамц, доктор (Sc.D), профессор, Гавъяат багш, МУБИС

Absract: “Educology” is English word which means fund of knowledge about the educational process; in Russian “Эдукология” is translated as “Educology” and system with multiside process of education is object of research, which is independent science called Educology. By this science individual’s education is studied about the multiside process interconnected with individuals upbringing, development, promotion, and behaviour in knowledge system in nature, social-human and psychological science’s education content and method.

The base content of Educology is studied by structure with individual education and its multi-process development, promotion; individual’s training-education complex process development; individual upbringing, development, behaviour education; individual knowledge management and training cognitive process education; individual psycho-physiological process education.

Content and method of educology issue, the base issue, faced issue and special course subjects in bachelor, master and doctor training (Mongolian Educational University, Orkhon University, Otgontenger University 1993-2015) has been taught for continuing 22 years. At the experience I wrote this article.

Түлхүүр үг: Бие хүний хөгжлийн иж бүрдэл, бие хүний хөгжил, төлөвшлийг судлах үйл явцын боловсрол, бие хүний мэдлэгийн болон сэтгэл зүйн чанар

Удиртгал

Энэхүү өгүүлэлд боловсрол судлал сургалтын явц, төгсгөлд оюутны ажиглах чадвар (нүдний хөгжил), сонсох чадвар (чихний хөгжил), бичих чадвар (тархины мэдрэлийн эсүүдийн удирдлагаар бие эрхний хөдөлгөөний эвсэл) гэх мэт бие бялдрын хөгжлийн; тухайн сэдвийн агуулгыг судлан эзэмшсэнээ амьдралдаа хэрхэн хэрэглэх зориулалт болон ач холбогдол бүхий нийгэмшлийн хөгжлийн; бие бялдрын болон нийгэмшлийн хөгжлийн шүтэлцээнд оюуны хөгжлийн ахиц өөрчлөлтийг судлан дүн шинжилгээ хийх

Судалгааны ажлын дээрх зорилгыг хангахын тулд

- Хүмүүжилд суурилсан сургалтын үйл явцын боловсролыг судлах
- Сургалтын үйл явцын шинэчлэлийг бакалаврын түвшинд судлах
- Боловсрол судлалын агуулга, аргазүйн асуудлыг оюутнууд судалж эзэмшсэний үр дүнд тэдний бие бялдрын, нийгэмшлийн болон оюуны хөгжлийн ахиц өөрчлөлтийг стандарт бус шалгуур үзүүлэлтээр судлан дүн шинжилгээ хийх зорилгыг дэвшүүлж байна.

Сургуулийн хөгжлийг төлөвшсөн багш мэргэжилтэн болон сургууль төгсөгчдийн улсдаа оруулж байгаа оюуны болон материаллаг хөрөнгө оруулалтын хэм хэмжээгээр тодорхойлно. Ийм хэрэгцээ, шаардлагад нийцүүлж багш мэргэжилтэн хүн хичээл сургалтын явц төгсгөлд суралцагчдын бие бялдрын, нийгэмшлийн болон оюуны хөгжлийн зохих хэмжээний төлөвшлийг судлах нь дэвшүүлж байгаа болон шийдвэрлэх үндсэн асуудал юм.

“Боловсрол судлал” сургалтын үйл ажиллагааны агуулга, аргазүйн асуудлыг энэхүү хичээлийн сэдэв бүрээр судлахдаа “Боловсрол судлалын үндэс” сурах бичгийн өгүүлбэр болгоныг оюутнаар олон дахин уншуулж, үг бүрийнх нь уялдаа холбоонд олон хувилбартай агуулга болгон ажиллаж чаддаг болговол тэд тухайн өгүүлбэрийн зөвхөн ил байгаа агуулгыг ойлгож эзэмших төдийгүй тухайн өгүүлбэрийг агуулгын багтаамжтай болгож ажиллахад тэдний бие бялдын, нийгэмшлийн болон оюуны хөгжилд ахиц өөрчлөлт гарах боломж бүрдэнэ. Энэхүү таамаглалаа баглах зорилгоор сурган хүмүүжүүлэх туршилтыг “Боловсрол судлалын үндэс” сурах бичгийн агуулга, аргазүйн хэмжээнд явуулсан болно.


Үндсэн хэсэг

Боловсролыг бие хүний бие бялдар, нийгэмшил, туршлагыг судлан дүн шинжилгээ хийх сурган хүмүүжүүлэх зүйн боловсролтой; ухамсарлах, хийсвэрлэх болон автомат үйл гүйцэтгэж оюун ухааныг яаж хөгжүүлдэгийг судлан дүн шинжилгээ хийх сэтгэл судлалын боловсролтой

холбон суралцагчдад зааж эзэмшүүлэх төдийгүй нийгмийн чадамж төлөвшүүлэх чиглэлээр багш мэргэшин ажиллавал аливаа суралцагч бие хүн насан туршдаа ажил үйл, амьдралаа “ертөнц” гэж үзэн түүндээ итгэл үнэмшилтэй хандан ирээдүйгээ урьдчилан зөв харах “ёс зүйн мэдлэг, чадвар” бүхий дотоод бодол, үзэл баримтлалтай болж, улмаар суралцагч бүр бие-сэтгэл-ухааныхаа нэгдэлд бие өөрийнхөө био-сфер, социо-сфер,

ноо-сфер хөгжлийн идэвхтэй төлөв болон идеал төлөвийг зөв оношлоход “бие хүний хөгжил, төлөвшлийн загвар” (Л. Жамц. “Боловсрол судлалын үндэс” УБ 2014. 15-р тал)-ыг чөлөөтэй ашигладаг болно.

Диаграмм 1
Бие хүний хөгжил, төлөвшлийн загвар




- “ Боловсрол судлал” сургалтын явцад бие хүний хөгжил, төлөвшлийн загварыг судлахдаа “Боловсрол судлалын үндэс” сурах бичгийн өгөгдсөн өгүүлбэрт зөв ашиглахын тулд эхлээд багшийн зөвлөгөөний дагуу сурган хүмүүжүүлэх зүйн боловсрол болон сэтгэл судлалын боловсролыг яаж хэрэгжүүлэхээ хичээлийн тодорхой сэдвийн хүрээнд судлан ажиллаж мэргэших шаардлагатай байна.

Жишээлбэл, сурган хүмүүжүүлэх зүйн, сэтгэл судлалын болон сэтгэц-физиологийн үйл явцын боловсролын интеграци нэгдэлд хичээлийн

тухайн сэдвийн агуулга, арга зүйг эзэмшсэн мэдлэг, чадвар, туршлагаа ашиглан суралцагчдын мэдлэгийн түвшин, хөгжил, төлөвшил, зан үйлийн ахиц өөрчлөлтийг судлан дүн шинжилгээ хийх үйл ажиллагааны эзэн болж хэрхэн мэргэшиж болохыг багш загварыг ашиглан сурах бичгийн тодорхой өгүүлбэр дээр суралцагчдыг бие даан ажилладаг болгоно. Энд л асар нарийн туршлага, чадамж шаардлагатай байна.

Диаграмм 2
Багшийн сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалын боловсролын агуулга, арга зүйн шүтэлцээ схем



Эх сурвалж: Л. Жамц. “Боловсрол судлалын үндэс” УБ 2014. 17-р тал


Дээрх схемийн нийгэмшлийн хөгжил, төлөвшил болон туршлагыг сурган хүмүүжүүлэх зүйн боловсролоор, оюун ухааны хөгжлийг сэтгэл судлалын боловсролоор, энэ хоёр боловсролын шүтэлцээ “сэтгэц-физиологийн хөгжил”-ийг дээд мэдрэлийн үйл ажиллагааны боловсролоор авч үзэж ажиллахад багшаас зөвхөн мэргэжлийн мэдлэг, чадвар, туршлага

төдийгүй сурган хүмүүжүүлэх зүйн, сэтгэл судлалын болон мэргэжлийн дидактикийн шүтэлцээ агуулга, аргазүйн асуудлыг хамарсан “Боловсрол судлал”-ын өргөн мэдлэг, чадвар, туршлага бүхий чадамж шаарддагийг боловсрол судлалын агуулга, аргазүйн асуудлыг бакалаврын түвшинд; боловсрол судлалын үндсийг боловсролын магистрын түвшинд; “Боловсрол

судлалын тулгамдсан асуудал” болон “Боловсрол судлалын тусгай курс” хичээлийг боловсролын докторын түвшинд тус тус зааж мэргэшсэн үйл ажиллагааныхаа явц, үр дүнгээр нотолсон болно.

Бие хүний хөгжил, төлөвшлийн загвар (диаграмм-1), “Багш мэргэжлийн боловсрол” (Жамц, 2014, х. 38)-ыг ашиглан суралцагчид хичээл бүрээр сурч эзэмших арга барилтай болох асуудлыг сурган хүмүүжүүлэх зүйн боловсролоор, сурах болон эзэмших үйлүүдтэй хэрхэн харилцаж ажиллах арга барилын асуудлыг сэтгэл судлалын

боловсролоор, сургалтын явц болон төгсгөлд суралцагчдын биеийн, нийгэмшлийн болон оюуны хөгжилд аль хэр ахиц өөрчлөлт гарч буйг судлан дүн шинжилгээ хийх асуудлыг сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалын боловсролоор тус тус авч үзэхэд “Боловсрол судлал” сургалтын онол, арга зүйн шинэчлэлийн судалгаа зайлшгүй шаардлагатай байдгийг бакалаврын, магистрын болон докторын сургалтын шүтэлцээнд судалж илрүүлсэн болно.



Дээрх схемийн бүтэц тус бүрийг уялдаа холбоонд нь ашиглан суралцагчдад тухайн хичээлээр ямар боловсрол олгох зорилгыг судалж буй сэдвийн агуулгын багтаамжтай; суралцагчдыг

хэрхэн хөгжүүлж төлөвшүүлэх зорилгыг хичээлийн сэдэв бүрийн агуулгыг хэрхэн эзэмшүүлэхэд ашиглах арга зүйн багтаамжтай холбон аливаа багш хүн мэргэжлийн мэдлэгээ


суралцагчдад хэрхэн эзэмшүүлэх арга барилыг сурган хүмүүжүүлэх зүйн мэдлэгээр; сургалтын явц болон төгсгөлд суралцагчдын шууд мэдрэн таних болон сэтгэж мэдрэн таних үйл явцуудад аль хэр ахиц өөрчлөлт гарч байгааг судлан дүн шинжилгээ хийх үйлтэй харилцах арга барилыг сэтгэл судлалын мэдлэгээр; сургалтын явц болон төгсгөлд суралцагчдын бие бялдрын, нийгэм-хүмүүнлэгийн болон оюуны хөгжилд гарч буй ахиц өөрчлөлтийг судлах үйлийн арга барилыг сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалын мэдлэг, чадвар, туршлага бүхий боловсролоор тус тус хэрэгжүүлнэ (энэ арга барилыг аливаа багш мэргэжилтэн олон дахин уншиж өөрийнхөө бие сэтгэл ухаанд буулган ажиллахыг хичээгээрэй).

Судалгааны ажлын дээрх үндэст тулгуурлан:

- Бүх шатны сургуулийн суралцагчдын мэдлэгийг 1, 2, 3, 4, 5 гэсэн цифрээр үнэлдэг уламжлалт хандлага; А, В, С, D, F гэсэн үсгэн үнэлгээгээр үнэлдэг кредит

хандлагыг өөрчлөн тэдний ажиглах, сонсох, бичих, ярих чадварыг сэтгэн бодох үйлтэй нь холбон судлахад жишиг болгож “сурах сонирхлын илрэл”, “сурах хандлага” болон “сурах сонирхлын төлөвшил”-ийн стандарт бус жишиг үзүүлэлтийг (Жамц, 2014, х. 44-48).

- тооцон өөрсдийн мэргэжлийн хичээлийн бүлэг сэдвийн агуулга, арга зүйн хэмжээнд стандарт бус үзүүлэлт боловсруулан хэрэгжүүлж болно
- “Сурагч, залуучуудын биеийн, нийгэм-хүмүүнлэгийн болон оюуны хөгжлийг тэдний мэдлэгийн чанар” болон “багшийн дүр төрх”-ийн шүтэлцээ бүхий бүтцийн элементүүдийн уялдаанд гурван блокоор авч үзсэнээ дараах схем (Жамц, 2014, х.118)-ээр үзүүлэв (Энэ схем нь 1993 онд ОХУ-ын Сурган хүмүүжүүлэх ухааны академид шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан диссертацийн гол агуулга юм).



Энэ схемд суралцагч залуучуудын бие хүний болон мэдлэгийн чанарыг нийгэмшлийн, оюун ухааны болон сэтгэц-физиологийн хөгжил, төлөвшил болон туршлагаар; харин багшийн дүр төрхийг түүний сурган хүмүүжүүлэх ур чадвар, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны сэтгэл зүйн бүтэц, багш мэргэжлийн зайлшгүй шинж чанар болон багш мэргэжлийн хэв маяг гэсэн бүтцүүдээр авч үзсэн болно. Энэ схемээс үзвэл бие хүний боловсролыг зөвхөн үйлчлэх үйл явц талаас нь төдийгүй амьдрах ухаан олж авах үйл явц, үр дүнгийн нэгдлээр авч үзнэ. Тухайлбал, хүний төрөлх хэлний хөгжил; төрсөн газар нутгаа хайрлан хамгаалах үзэл бодол бүхий мэдлэг, туршлага; хот хөдөөгийнхний болон залуучууд ахмадуудын хөгжил гэх мэт хүн ам зүйн бодлогын асуудал; ажил мэргэжлийн нийтлэг; үндэстэн ястны өв уламжлал, соёл бүхий социал харилцааны боловсролыг боловсролын социологоор; хүн үүссэн үеэс өнөөг хүртэлх хүмүүсийн сэтгэлгээний хөгжлийн үе шатны асуудлыг боловсролын түүхээр; “газар-хүн-огторгуй” шүтэлцээнд хүний мэдлэг, чадвар, туршлага бүхий чадамж болон ажил үйл, амьдралыг тоо, чанар, үр ашиг, өгөөжийн нэгдэлд судлах боловсролыг боловсролын философиор тус тус авч үзнэ (Жамц, 2014, х.57-67).

Багш нар хичээлийн тухайн сэдвийг юу заах (агуулга), яаж заах (аргазүй), хэн заах (багшийн загвар), хэнд заах (суралцагчийн загвар) гэсэн өөр хоорондоо салшгүй уялдаа холбоотой нэгдмэл үйл ажиллагаагаар боловсруулж ажиллахад мэргэжлийн онол, арга зүйн мэдлэг, чадвар, туршлага шаардлагатай байдаг юм. Энэ шаардлагыг хэрэгжүүлэхийн тулд заах сэдвийнхээ агуулгын багтаамжийг хэрхэн боловсруулж гаргах үйл ажиллагааг зөв гүйцэтгэх нь чухал бөгөөд энд л багшаас мэргэжлийн өргөн мэдлэг төдийгүй сурган хүмүүжүүлэх зүйн, сэтгэл судлалын болон мэргэжлийн дидактикийн мэдлэг, чадвар, туршлага зайлшгүй шаардана. Жишээлбэл, энэ үйл ажиллагааны гол агуулгыг “тухайн багш хичээлээ нэг сар заалаа. Энэ хугацаанд тухайн сэдвийг ойлгож эзэмшсэний үр дүнд суралцагчдын нүд (уншиж ажиглах чадвар)-ний хөгжил, чих (сонссоноо ойлгох чадвар)-ний хөгжил, бичих болон ярьж тайлбарлах чадвар бүхий сэтгэхүйн хөгжил аль хэр өөрчлөгдөв? гэсэн оновчтой асуултанд чөлөөтэй хариулах боломж хэрхэн бүрдсэн”-ээр л тодорхойлсон. Энэ агуулгын бүтэц нь:

- “Стандарт бус үнэлгээ”-г агуулга, аргазүй нэгдэлд нь боловсруулах үндэслэл

- Суралцагчдын бие бялдар, нийгэмшил, оюун-сэтгэцийн хөгжлийг ямар арга барилаар оношлон үнэлэх аргазүй
- Суралцагчдын ажиглах, сонсох, бичиж тэмдэглэх болон ярьж тайлбарлан сэтгэн бодох үйлүүд тэдний бие бялдар, нийгэмшил, оюун-сэтгэцийн хөгжилтэй ямар хамааралтай, яаж уялддагийг хичээлийн явц, төгсгөлд тооцон дүн шинжилгээ хийж ажиллах мэдлэг, чадвар, туршлага
- Суралцагчдын бие бялдар, нийгэмшил, оюун-сэтгэцийн хөгжил нь тэдний мэдлэг, чадвартай яаж холбогддогийг тооцон ажиллах хандлага. Эдгээр агуулгыг “Боловсрол судлал” хичээлийн 8 цагийн сургалтын үйл ажиллагаагаар судалж үзсэн болно.
- Отгонтэнгэр их сургуульд “Боловсрол судлал” хичээлийг тухайн хичээлийн жилийн эхний хагаст 32 цагийн лекц, 64 цагийн семинар, 96 цагийн бие даалт бүхий сургалтаар зааж оюутнуудын эзэмшсэн мэдлэг, чадварыг шалгалтаараа үнэлэн дүгнэсний дараа өөрийн зохиосон “Боловсрол судлалын үндэс” сурах бичгийн 56-р хуудасны 142 үг бүхий 6 өгүүлбэрийг 84 оюутанд 3 удаа уншиж өгөөд ойлгосноо бичих даалгаврыг 20 минутанд гүйцэтгүүлсэн. Даалгавар гүйцэтгэсний дараа тэдний зайлшгүй бичих ёстой утга агуулгыг багш бичүүлсэн. Оюутнуудаас өөрийнхөө бичсэнийг багшийн бичүүлсэнтэй жишин дүн шинжилгээ хийхийг хүссэн. Энэ туршилтын үр дүнг дор сийрүүлэв.
- 84 оюутны 61 буюу 72,6% нь цаашид сонсох чадвараа сайжруулан хөгжүүлэх шаардлагатайгаа олж мэдлээ
- 74 буюу 88% нь багшийн заасан хичээлийг ойлгосон боловч энэ хичээлийн гол агуулгатай холбоотой материалыг сонсож ойлгох чадвар дутагдалтай байгаа юм байна
- 78 буюу 93% нь сонсох чадвараа хөгжүүлэх шаардлагатайгаа мэдлээ
- 79 буюу 94% нь сурах бичгийн тухайн агуулгын ил утгыг сонсож ойлгосон атлаа далд утгыг нь гаргаж чаддаггүй юм байна.
- Сонссон материалаа өөрийн болгож хөгжүүлэх чиглэлээр дасгал олон дахин хийх хэрэгтэй гэж 64 буюу 76,2% нь үзжээ.
- Сонссон материалынхаа утгыг бүрэн гаргахад уншиж ойлгох чадвар төдийлөн

сайн нөлөөлдөггүй юм байна гэж 58 буюу 69% нь үзжээ

- Би 20, 21 нас хүрлээ. Сонсох чадвараа хөгжүүлэхийг анхаарахгүй өдий хүрсэнээ мэдлээ гэж 66 буюу 78,4% нь бичжээ.
- Мөн сурах бичгийн 25-р хуудасны 160 үг бүхий 6 өгүүлбэрийг дээрх судалгаанд оролцсон 84 оюутан 3 удаа уншиж, ойлгосноо бичих даалгаврыг 20 минутад гүйцэтгэсэн. Даалгавраа бичээд дуусмагц тэдний бичих ёстой агуулгыг багш тэдэнд бичүүлсэн. Энэ хоёр бичлэгийг харьцуулан даалгавар яаж гүйцэтгэсэндээ дүн шинжилгээ хийхийг тэднээс хүссэн юм.
- 84 оюутны 71 буюу 84,5% нь уншсан материалынхаа 60,2%-82,4%-ийг бичсэн байна гэжээ. Энэ нь жишээ баримт ашиглан тайлбарлан ярьсан сэдэвтэй холбоотой материалыг сурах бичгээс уншиж ойлгох үйл нь сурах бичгийн дурын сэдэвтэй холбоотой материалыг шууд сонсож ойлгох үйлээс сэтгэн бодох чадвар сайн байгааг харуулж байгаа юм. Өөрөөр хэлбэл, сурах бичгээс унших явцдаа ажиглах чадвараа (нүдний хөгжлөө) сайн анхаарч ажиллах шаардлагатай юм.
- 31 оюутан буюу 36,9% нь 46,3%-54,2%-ийг, үлдэх 19 оюутан буюу 22,6% нь 30,2%-41,4%-ийг тус тус бичсэн байна гэжээ. Энэ нь оюутнууд сурах бичгээс уншиж ойлгох үйл нь сонсож ойлгох үйлээсээ илүү байдаг боловч сонсох чадвараа хөгжүүлэхдээ уншиж, ажиглах чадвараа ашиглах шаардлагатайг харуулж байгаа юм.

ДҮГНЭЛТ

- Дээр өгүүлсэн туршилтын зарим үр дүн нь суралцагчдын зөвхөн чих гэдэг эрхтний сонсох чадварын хөгжлийг төдийгүй бие бялдрын, нийгэмшлийн болон оюуных нь хөгжлийн асуудалтай холбож тухайн хичээлийн агуулга, аргазүйн асуудлыг авч үзэх шаардлагатайг харуулж байгаа юм. Жишээлбэл, оюутны зөвхөн нүд гэдэг эрхтний хөгжлийг төдийгүй бие бялдрын, нийгэмшлийн болон оюуны хөгжлийг хичээлийн тухайн сэдвүүдээр хэрхэн судалж шийдвэрлэхэд сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалын боловсрол зайлшгүй шаардлагатайг энэ туршилтаар илрүүлсэн болно.

- Аль ч мэргэжлийн багш хичнээн олон жил багшилж дадлага, туршлагатай болсон ч зааж буй хичээлийнхээ сэдэв бүрийн агуулгын багтаамжийг аль хэр түвшинд боловсруулан гаргаж, хэрэгжүүлж чадаж байгаа эсэхдээ байнгын эрэл хайлт, дүн шинжилгээ хийж ажиллахад сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалын мэдлэг, чадвар, туршлага бүхий боловсрол зайлшгүй шаардлагатайг эрхэм зорилго болгох нь чухал байдгийг энэ туршилтын явц, үр дүнгээр илрүүлсэн болно.
- Бүлэг сэдвийн гол агуулгыг хамарсан материалыг сурах бичгээсээ сонгон авч, түүний бүтцийг судлан ажиллах мэргэжлийн мэдлэг, чадвар, туршлагыг багш эзэмшсэн цагт суралцагчдынхаа бие бялдар, нийгэмшил, оюуны хөгжлийг хичээлийн сэдэв бүрээрээ судлан дүн шинжилгээ хийж ажиллах боломжтой болно.
- Багшийг Сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалын мэдлэг, чадвар, туршлага бүхий боловсролтой мэргэжилтэн болгож төгсгөх нь багш бэлтгэдэг сургуулиудын хөгжлийг тодорхойлох нэг чухал үзүүлэлт болохыг дэвшүүлсэн таамаглалаараа нотлон харуулсан болно.

Энэ сургалтын үйл явцад сурагчдын бие бялдар, нийгэмшил, оюуны хөгжил яаж өөрчлөгдөж байгааг одоо мөрдөж байгаа кредит үнэлгээгээр үнэлж дүгнэх боломжгүй. Энэ тохиолдолд хичээл сургалтын явц болон төгсгөлд суралцагчдын сурах сонирхлын илрэл, сурах хандлага, сурах сонирхлын төлөвшил гэх стандарт бус үнэлгээ зайлшгүй хэрэгтэйг сургалт, боловсролын байгууллагад тасралтгүй 50 жил хичээл, сургалтын үйл ажиллагааг олон хувилбараар, бас явц тус бүрт нь шинэчлэл өөрчлөлт хийж ажилласны үр дүнгээр нотлон харуулсан болно.

Ингэхлээр багш нараас хичээлийнхээ тухайн сэдвийн агуулгын багтаамжийг сайн боловсруулж, түүнийхээ бүтэц тус бүрээр сурагчдыг сэтгэн бодуулж ажиллаж чаддаг болгоход зохицсон сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалын боловсрол шаардах болж байгаа юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Жамц, Л., Намжилмаа, Ц. (2010). *Багшийн сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалын боловсролын үндэс*. Улаанбаатар
- Беспалько, В.П. Слагаемые педагогической технологии. *Педагогика*. Москва
- Фролов, И.Т ба бус. (1990). Введение в философию (Учебник для высших учебных заведений) .II. Изд. *Политической литературы*, С.124-125
- Фролова, И.Т. (под ред). (1991). *Философский словарь*. Изд. Политической литературы. Москва, с. 408
- Решетова, З.А. (1985). *Психологические основы профессионального обучения*. Изд. Мосуниверситета. с.54
- Жамц, Л. (2004). Боловсрол судлалыг хүн судлалын үүднээс авч үзэх нь. *ХИС-ийн э/ш-ний бичиг*, х.104-108
- Жамц, Л. (2015). Механик хэмжигдэхүүнүүдийг тогтолцооны онолоор судлах нь. *Дидактические основы обучения по физике*. Улаанбаатар
- Гершунский, Б.С. (1998). Философия образования для XXI века. Совершенство, Москва, с.55
- Солсо, Р.Л. (2002). *Когнитивная психология (Когнитивное развитие)*. Москва
- Даваа, Ж., Жамц, Л., Содов, Ц., Сүхбат, Г. (2011). *Боловсрол судлалын үндэс*. Улаанбаатар
- Намжилмаа, Ц. (2008). Багшийн сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалын боловсролын зарим асуудлыг судалсан нь. *Диссертаци*, х.37
- Жамц, Л. (1993). Педагогические основы профессиональной ориентации среди учащейся молодежи Монголии. *Автореферат*. Москва
- James, M.Royer., Robert, S.Feldman. (1984). *Educatoinal psychology. Applications and Thery Publishes in the U.S by Alfred A.Knorf*, Lnc8 New york
- Mietzel, G. (1988). *Paedagogische Psychogogie Lernens und Lehrens*
- Зимняя, И.А. (2001). Педагогическая психология. *Логос*, стр.7
- Пиаже, Ж. (1966). Психология, междисциплинарные связи и система наук //XVШ *Международный психологический конгресс*, стр.155
- Петровского, А.В. (Под ред). (1996). Введение в психологию. Москва
- Ronald, W.Rebore. (1991). *Personal Adminstation in Education. A.Management Approach*. New Jersey: Prenice-Hall8 Lnc
- Жамц, Л. (2013). Ерөнхий сэтгэл судлал. Улаанбаатар
- Туяа, Б. (2003). *Бие хүний сэтгэл зүй, сэтгэц заслын өрнөдийн онол, гол төлөөлөгчид*. Улаанбаатар